



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

2023 оны 04 дүгээр сарын 17
№15 (1263)

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР



ГАРЧИГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

224.	Олон нийтийн сүлжээнд хүний эрхийг хамгаалах тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай	1123
225.	Харилцаа холбооны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай	1124
226.	Кибер аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай	1125
227.	Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуульд нэмэлт оруулах тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай	1126
228.	Татварын ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай	1127

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

229.	Журам батлах тухай	Дугаар 409	1128
230.	Төслийн жагсаалт шинэчлэн батлах тухай	Дугаар 442	1135



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны 03 дугаар сарын 30-ны өдөр

Улаанбаатар хот

ОЛОН НИЙТИЙН СҮЛЖЭЭНД ХҮНИЙ ЭРХИЙГ ХАМГААЛАХ ТУХАЙ ХУУЛЬ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.2023 оны 01 дүгээр сарын 20-ны өдөр баталсан Олон нийтийн сүлжээнд хүний эрхийг хамгаалах тухай хуулийг хүчингүй болсонд тооцсугай.

2 дугаар зүйл.Энэ хуулийг 2023 оны 03 дугаар сарын 30-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Г.ЗАНДАНШАТАР

Mongol State Court

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠨ ᠬᠤᠷᠭᠠᠨ ᠶ᠋ᠢᠨ ᠳᠠᠷᠭ᠋᠎ᠠ

ᠨᠢᠯᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠨ ᠬᠤᠷᠭᠠᠨ ᠶ᠋ᠢᠨ ᠳᠠᠷᠭ᠋᠎ᠠ
ᠶ᠋ᠢᠨ ᠬᠤᠷᠭᠠᠨ ᠶ᠋ᠢᠨ ᠳᠠᠷᠭ᠋᠎ᠠ

ᠨᠢᠯᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠨ ᠬᠤᠷᠭᠠᠨ ᠶ᠋ᠢᠨ ᠳᠠᠷᠭ᠋᠎ᠠ
ᠶ᠋ᠢᠨ ᠬᠤᠷᠭᠠᠨ ᠶ᠋ᠢᠨ ᠳᠠᠷᠭ᠋᠎ᠠ

ᠨᠢᠯᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠨ ᠬᠤᠷᠭᠠᠨ ᠶ᠋ᠢᠨ ᠳᠠᠷᠭ᠋᠎ᠠ
ᠶ᠋ᠢᠨ ᠬᠤᠷᠭᠠᠨ ᠶ᠋ᠢᠨ ᠳᠠᠷᠭ᠋᠎ᠠ

ᠶ᠋ᠢᠨ ᠬᠤᠷᠭᠠᠨ ᠶ᠋ᠢᠨ ᠳᠠᠷᠭ᠋᠎ᠠ
ᠶ᠋ᠢᠨ ᠬᠤᠷᠭᠠᠨ ᠶ᠋ᠢᠨ ᠳᠠᠷᠭ᠋᠎ᠠ



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны 03 дугаар
сарын 30-ны өдөр

Улаанбаатар
хот

ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛЬ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.2023 оны 01 дүгээр сарын 20-ны өдөр баталсан Харилцаа холбооны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг хүчингүй болсонд тооцусгай.

2 дугаар зүйл.Энэ хуулийг 2023 оны 03 дугаар сарын 30-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Г.ЗАНДАНШАТАР

Mongolian State Information Agency

Хуульчилсан үсэг / ᠬᠤᠰᠢᠯᠠᠭᠤᠯᠠᠭᠤᠨ ᠤᠯᠤᠰ / ᠨᠠᠭᠤᠯᠠᠭᠤᠨ ᠤᠯᠤᠰ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ-ᠶᠡᠬᠡ ᠶᠡᠬᠡᠨ ᠶᠡᠬᠡᠨ
ᠶᠡᠬᠡᠨ ᠶᠡᠬᠡᠨ ᠶᠡᠬᠡᠨ ᠶᠡᠬᠡᠨ ᠶᠡᠬᠡᠨ
ᠶᠡᠬᠡᠨ ᠶᠡᠬᠡᠨ ᠶᠡᠬᠡᠨ ᠶᠡᠬᠡᠨ ᠶᠡᠬᠡᠨ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ-ᠶᠡᠬᠡ ᠶᠡᠬᠡᠨ ᠶᠡᠬᠡᠨ
ᠶᠡᠬᠡᠨ ᠶᠡᠬᠡᠨ ᠶᠡᠬᠡᠨ ᠶᠡᠬᠡᠨ ᠶᠡᠬᠡᠨ
ᠶᠡᠬᠡᠨ ᠶᠡᠬᠡᠨ ᠶᠡᠬᠡᠨ ᠶᠡᠬᠡᠨ ᠶᠡᠬᠡᠨ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ-ᠶᠡᠬᠡ ᠶᠡᠬᠡᠨ ᠶᠡᠬᠡᠨ
ᠶᠡᠬᠡᠨ ᠶᠡᠬᠡᠨ ᠶᠡᠬᠡᠨ ᠶᠡᠬᠡᠨ ᠶᠡᠬᠡᠨ
ᠶᠡᠬᠡᠨ ᠶᠡᠬᠡᠨ ᠶᠡᠬᠡᠨ ᠶᠡᠬᠡᠨ ᠶᠡᠬᠡᠨ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ-ᠶᠡᠬᠡ ᠶᠡᠬᠡᠨ ᠶᠡᠬᠡᠨ
ᠶᠡᠬᠡᠨ ᠶᠡᠬᠡᠨ ᠶᠡᠬᠡᠨ ᠶᠡᠬᠡᠨ ᠶᠡᠬᠡᠨ
ᠶᠡᠬᠡᠨ ᠶᠡᠬᠡᠨ ᠶᠡᠬᠡᠨ ᠶᠡᠬᠡᠨ ᠶᠡᠬᠡᠨ



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны 03 дугаар сарын 30-ны өдөр

Улаанбаатар хот

ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ХУУЛЬД
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ
ХУУЛЬ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД
ТООЦОХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.2023 оны 01 дүгээр сарын 20-ны өдөр баталсан Татварын ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийг хүчингүй болсонд тооцсугай.

2 дугаар зүйл.Энэ хуулийг 2023 оны 03 дугаар сарын 30-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Г.ЗАНДАНШАТАР

Mongol Folio_02.html

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠨ ᠬᠤᠭᠣᠯᠠᠭ ᠠᠨᠠᠭᠤᠯᠤᠯᠤᠰ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠨ
ᠶ᠋ᠢᠨᠭᠣᠨᠠᠨᠠᠭᠤᠯᠤᠯᠤᠰ
ᠶ᠋ᠢᠨᠭᠣᠨᠠᠨᠠᠭᠤᠯᠤᠯᠤᠰ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠨ ᠬᠤᠭᠣᠯᠠᠭ ᠠᠨᠠᠭᠤᠯᠤᠯᠤᠰ
ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠨ ᠬᠤᠭᠣᠯᠠᠭ ᠠᠨᠠᠭᠤᠯᠤᠯᠤᠰ
ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠨ ᠬᠤᠭᠣᠯᠠᠭ ᠠᠨᠠᠭᠤᠯᠤᠯᠤᠰ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠨ ᠬᠤᠭᠣᠯᠠᠭ ᠠᠨᠠᠭᠤᠯᠤᠯᠤᠰ
ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠨ ᠬᠤᠭᠣᠯᠠᠭ ᠠᠨᠠᠭᠤᠯᠤᠯᠤᠰ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠨ ᠬᠤᠭᠣᠯᠠᠭ ᠠᠨᠠᠭᠤᠯᠤᠯᠤᠰ
ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠨ ᠬᠤᠭᠣᠯᠠᠭ ᠠᠨᠠᠭᠤᠯᠤᠯᠤᠰ



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2022 оны 11 дүгээр
сарын 16-ны өдөр

Дугаар 409

Улаанбаатар
хот

Журам батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн 6.1.5, 16.4-т заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1.“Төрийн өмчит эрдэм шинжилгээний хүрээлэн, төвийн судалгааны үндсэн чиглэлийг тодорхойлох, санхүүжүүлэх журам”-ыг хавсралт ёсоор баталсугай.

2.Энэ журмын хэрэгжилтийг хангаж, хяналт тавьж ажиллахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгаланд үүрэг болгосугай.

3.Энэ журам гарсантай холбоотойгоор төрийн өмчит эрдэм шинжилгээний хүрээлэн, төвийн судалгааны үндсэн чиглэлд шаардагдах хөрөнгийг жил бүрийн улсын төсөвт тусган санхүүжүүлж ажиллахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, Сангийн сайд Б.Жавхлан нарт даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

Л.ОЮУН-ЭРДЭНЭ

**БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ
УХААНЫ САЙД**

Л.ЭНХ-АМГАЛАН

Засгийн газрын 2022 оны 409 дүгээр
тогтоолын хавсралт

ТӨРИЙН ӨМЧИТ ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХҮРЭЭЛЭН, ТӨВИЙН СУДАЛГААНЫ ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙГ ТОДОРХОЙЛОХ, САНХҮҮЖҮҮЛЭХ ЖУРАМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Энэ журмын зорилго нь төрийн өмчит, улсын төсвөөс санхүүждэг эрдэм шинжилгээний хүрээлэн, төв (цаашид “хүрээлэн, төв” гэх)-үүдийг тогтвортой хөгжүүлэх, биет болон биет бус нөөц, хүний нөөцийн чадавхыг бүрэн ашиглах нөхцөлийг бүрдүүлж, тэдгээрийн шинжлэх ухааны судалгааны үндсэн чиглэлийг тодорхойлж, үр дүнд суурилсан санхүүжилт олгохтой холбогдон үүсэх харилцааг зохицуулахад оршино.

1.2.Энэ журамд хэрэглэсэн дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

1.2.1.“судалгааны үндсэн чиглэл” гэж шинжлэх ухаан, технологийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас тухайн хүрээлэн, төвөөр тодорхой хугацаанд гүйцэтгүүлэхээр баталсан судалгаа хөгжүүлэлтийн ажлын сэдэвчилсэн чиглэлийг;

1.2.2.“судалгааны үндсэн чиглэлийн санхүүжилт” гэж судалгааны үндсэн чиглэлээ хэрэгжүүлэхэд зориулан хүрээлэн, төвд улсын төсвөөс тогтмол олгож байгаа мөнгөн хөрөнгийг.

1.3.Хүрээлэн, төвийн судалгааны үндсэн чиглэлийг шинжлэх ухаан, технологийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний шийдвэр гарсан өдрөөс эхлэн хэрэгжүүлж, 5 жил тутамд тодотгол хийнэ.

Хоёр.Судалгааны үндсэн чиглэлийг тодорхойлох, батлах

2.1.Судалгааны үндсэн чиглэлийг Монгол Улсын урт, дунд хугацааны хөгжлийн бодлого, Монгол Улсын шинжлэх ухаан, технологийг хөгжүүлэх тэргүүлэх чиглэл, цөм технологийн жагсаалт, улс орны эдийн засаг, нийгмийн хэрэгцээ шаардлага, хүрээлэн буй орчны асуудал, шинжлэх ухааны хөгжлийн олон улсын чиг хандлагатай уялдуулан тодорхойлно.

2.2.Хүрээлэн, төвүүдийн судалгааны үндсэн чиглэл нь тухайн

байгууллагын үйл ажиллагааны стратегийн зорилт, судалгааны ажлын туршлага, дэд бүтэц, хүний нөөцийн чадавхад тулгуурласан байна.

2.3.Хүрээлэн, төв нь өөрийн хэрэгжүүлэх судалгааны үндсэн чиглэлийн талаарх саналыг Эрдмийн зөвлөлийн хурлаараа хэлэлцүүлж, тухайн жилийн 12 дугаар сарын 1-ний өдрийн дотор харьяалах дээд шатны байгууллагадаа хүргүүлнэ.

2.4.Харьяалах дээд шатны байгууллага нь ажлын 5 хоногт багтаан энэ журмын 2.3-т заасан саналыг судалж, дүгнэлт гарган шинжлэх ухаан, технологийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад албан бичгээр хүргүүлнэ.

2.5.Шинжлэх ухаан, технологийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага энэ журмын 2.4-т заасан санал, дүгнэлтэд хянан магадалгаа хийж, судалгааны үндсэн чиглэлийн жагсаалтыг гарган шинжлэх ухаан технологийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний шийдвэрээр батална.

2.6.Хүрээлэн, төвийн судалгааны үндсэн чиглэлд дараахь тохиолдолд өөрчлөлт оруулна:

2.6.1.Засгийн газрын шийдвэрээр хүрээлэн, төвийг өөрчлөн байгуулсан;

2.6.2.хүрээлэн, төвийн Эрдмийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлсэн судалгааны үндсэн чиглэлдээ өөрчлөлт оруулах тухай саналыг харьяалах дээд шатны байгууллага нь үндэслэлтэй гэж үзсэн.

2.7.Шинжлэх ухаан, технологийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага энэ журмын 2.6.2-т заасан санал, дүгнэлтэд хянан магадалгаа хийж өөрчлөлт оруулах эсэхийг шийдвэрлэнэ.

2.8.Энэ журмын 2.7-д заасны дагуу өөрчлөлт оруулсан судалгааны үндсэн чиглэлтэй уялдуулан тухайн хүрээлэн, төв нь дотоод бүтэц, зохион байгуулалтаа өөрчлөн тогтоож болно.

Гурав.Гэрээ байгуулах, санхүүжүүлэх

3.1.Судалгааны үндсэн чиглэл батлагдсанаас хойш 30 хоногийн дотор шинжлэх ухаан, технологийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн холбогдох хүрээлэн, төвийн төсвийн шууд захирагчтай судалгааны үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх, санхүүжүүлэх гэрээг 5 жилийн хугацаатай байгуулна.



3.2. Хүрээлэн, төвийн судалгааны үндсэн чиглэлийн санхүүжилтэд шаардагдах хөрөнгийг шинжлэх ухаан, технологийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тухайн жилийн улсын төсөвт тусган санхүүжүүлнэ.

3.3. Энэ журмын 3.2-т заасан санхүүжилтийг дараахь зориулалтаар зарцуулна:

3.3.1. судалгаа, туршилт хийх, дээж шинжлүүлэх, урвалж бодис худалдан авах;

3.3.2. мэргэжлийн хянан магадалгаа бүхий олон улсын эрдэм шинжилгээний сэтгүүлд өгүүлэл нийтлүүлэх, бодлогын зөвлөмж боловсруулах;

3.3.3. оюуны өмч, зохиогчийн эрх болон аж үйлдвэрийн өмч бүртгүүлэх, мэдүүлэх, тусгай зөвшөөрөл авах;

3.3.4. суурин судалгааны төв, мониторингийн цэг, байнгын станц ажиллуулах;

3.3.5. эрдэм шинжилгээний хурал, семинар, үзэсгэлэн зохион байгуулах, мэргэжлийн сэтгүүлийг хөгжүүлэх;

3.3.6. эх бэлтгэл, ном хэвлүүлэх, судалгааны сан хөмрөг бүрдүүлэх;

3.3.7. дотоод, гадаад томилолтоор ажиллуулах, социологийн болон хээрийн судалгаа (экспедиц) явуулах;

3.3.8. лабораторийн туршилт, шинжилгээ, баталгаажуулалт, магадлан итгэмжлэл, хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах;

3.3.9. архив, номын сангийн үйлчилгээний төлбөр;

3.3.10. судалгаа, туршилт, малтлагын зориулалттай бага оврын техник, багаж, тоног төхөөрөмж болон компьютер, программ хангамж, тэдгээрийн сэлбэг хэрэгсэл худалдан авах, суурилуулах, засвар үйлчилгээ хийх.

3.4. Хүрээлэн, төв нь судалгааны үндсэн чиглэлд олгохоор баталсан санхүүжилтийн хуваарилалтыг Эрдмийн зөвлөлийн хурлаараа хэлэлцүүлэн батлуулна.

3.5.Санхүүжилтийг үр ашигтай зарцуулах, хуваарилах, хэрэгжилтийг зохион байгуулах, хяналт тавих, тайлагнах үүргийг тухайн хүрээлэн, төвийн төсвийн шууд захирагч хүлээнэ.

3.6.Хүрээлэн, төвийн судалгааны үндсэн чиглэлд олгох санхүүжилтийн хэмжээг тооцох, хуваарилах аргачлалыг шинжлэх ухаан, технологийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батлан мөрдүүлнэ.

Дөрөв.Үр дүнг баталгаажуулах, хяналт тавих

4.1.Судалгааны үндсэн чиглэлийн хэрэгжилтийн явц, үр дүн, санхүүжилтэд шинжлэх ухаан, технологийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон Шинжлэх ухаан, технологийн сан, төсвийн шууд захирагч нар хамтран хяналт тавина.

4.2.Судалгааны үндсэн чиглэлийн санхүүжилтээр хийгдсэн судалгаа хөгжүүлэлтийн ажлын үр дүнг дараахь баримт бичгүүдээр баталгаажуулна:

4.2.1.эрдэм шинжилгээний болон хээрийн судалгаа (экспедиц)-ны тайлан, нэгэн сэдэвт бүтээл, ном, мэргэжлийн хянан магадалгаа бүхий гадаад, дотоодын сэтгүүлд хэвлүүлсэн эрдэм шинжилгээний бүтээл, өгүүлэл, илтгэл;

4.2.2.стандарт, норм, нормативын баримт бичиг;

4.2.3.онолын үндэслэл, бодлогын үзэл баримтлал, баримт бичиг, зөвлөмж;

4.2.4.оюуны өмч, зохиогчийн эрх, техник, эдийн засгийн урьдчилсан судалгаа;

4.2.5.заавар, зөвлөмж, гарын авлага, аргачлал, эмчилгээ, оношилгоо, сэргийлэлтийн шинэ дэвшилтэт арга, омог, сорт, үүлдэр, математик загвар, тооцоо, бодлогын алгоритм, программ хангамж, мэдээллийн болон өгөгдлийн сан, зураг, зураглал, каталоги, үзэсгэлэн, танин мэдэхүйн контент.

4.3.Хүрээлэн, төв нь энэ журмын 3.1-д заасан судалгааны үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх, санхүүжүүлэх гэрээний дагуу гүйцэтгэсэн ажлын тайлангаа жил бүрийн 12 дугаар сарын 10-ны өдрийн дотор албан бичгээр болон цахимаар шинжлэх ухаан, технологийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

4.4.Шинжлэх ухаан, технологийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага жил бүр судалгааны үндсэн чиглэлээр хэрэгжүүлсэн ажлын үр дүнг хэлэлцэн, үргэлжлүүлэн санхүүжүүлэх эсэх асуудлыг шийдвэрлэнэ.

4.5.Судалгааны үндсэн чиглэлээр хэрэгжүүлэх, санхүүжүүлэх гэрээний жилийн ажлын үр дүн хангалтгүй гэж үзвэл, гэрээний нөхцөлийг хангуулах арга хэмжээ авч, шаардлагатай гэж үзвэл санхүүжилтийг зогсоох хүртэл арга хэмжээ авч болно.

Тав.Үр дүнг тайлагнах, хүлээлгэн өгөх, хариуцлага тооцох

5.1.Хүрээлэн, төв нь энэ журмын 3.1-д заасан хугацаа дууссан судалгааны ажлын тайланг Эрдмийн зөвлөлийн хурлаараа хэлэлцүүлж өөрийн харьяалах дээд шатны байгууллагад хүргүүлэн тухайн оны 12 дугаар сарын 1-ний өдрийн дотор багтаан дүгнэлт гаргуулна.

5.2.Харьяалах дээд шатны байгууллага нь тайланг дүгнэлтийн хамт шинжлэх ухаан, технологийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тухайн оны 12 дугаар сарын 15-ны өдрийн дотор хүргүүлнэ.

5.3.Хүрээлэн, төвийн судалгааны үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх, санхүүжүүлэх гэрээний гүйцэтгэл, үр дүнд хянан магадалгаа хийж, дүгнэлт гаргах үүрэг бүхий орон тооны бус шинжээчийн багийг шинжлэх ухаан, технологийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн томилон ажиллуулна.

5.4.Шинжлэх ухаан, технологийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын шинжлэх ухаан, технологийн асуудал хариуцсан нэгж шинжээчийн багтай хамтран ажиллаж дүнг нэгтгэн, тайлангийн үнэлгээг шинжлэх ухаан, технологийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд танилцуулна.

5.5.Гэрээнд заасан ажлын үр дүнг хангалтгүй гэж үнэлсэн тохиолдолд төсвийн шууд захирагчид гэрээний гүйцэтгэлийг хангуулах хугацаатай үүрэг даалгавар өгч, үүрэг даалгаврыг биелүүлээгүй тохиолдолд хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага тооцож, хохирлыг буруутай этгээдээр төлүүлэх арга хэмжээ авна.

5.6.Хүрээлэн, төв нь нэгдсэн тайлангаа шинжлэх ухаан, технологийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дүгнэлтийн хамт дараа оны 3 дугаар сард багтаан шинжлэх ухаан, технологийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан



“Шинжлэх ухаан, технологийн төсөл хэрэгжүүлэх журам”-д заасан “Итгэмжлэн хадгалагч”-д хүлээлгэн өгнө.

5.7.Судалгааны үндсэн чиглэл тогтоох, санхүүжүүлэхтэй холбогдон үүссэн маргааныг шинжлэх ухаан, технологийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хүлээн авч шийдвэрлэнэ.

5.8.Гомдол гаргагч энэ журмын 5.7-д заасан шийдвэрийг эс зөвшөөрвөл холбогдох хуулийн дагуу шүүхээр шийдвэрлүүлнэ.

---o0o---

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2022 оны 12 дугаар
сарын 7-ны өдөр

Дугаар 442

Улаанбаатар
хот

Төслийн жагсаалт шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1.Монгол Улс, Европын сэргээн босголт, хөгжлийн банк хооронд 2019 оны 4 дүгээр сарын 9-ний өдөр байгуулсан Санхүүжилтийн ерөнхий хэлэлцээрийн хүрээнд 300 сая ам.доллартой тэнцэх зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төслийн жагсаалтыг хавсралт ёсоор шинэчлэн баталсугай.

2.Энэ тогтоолын хавсралтад заасан төслийг хэрэгжүүлэх талаар Европын сэргээн босголт, хөгжлийн банктай тохиролцож, холбогдох гэрээ хэлэлцээрийг байгуулах арга хэмжээ авахыг Сангийн сайд Б.Жавхланд, төслийг цаг хугацаанд нь үр дүнтэй хэрэгжүүлэх арга хэмжээ авч ажиллахыг Засгийн газрын холбогдох гишүүдэд тус тус даалгасугай.

3.Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Төслийн жагсаалт батлах тухай” Засгийн газрын 2019 оны 9 дүгээр сарын 18-ны өдрийн 356 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

Л.ОЮУН-ЭРДЭНЭ

САНГИЙН САЙД

Б.ЖАВХЛАН



Засгийн газрын 2022 оны 442 дугаар
тогтоолын хавсралт

**МОНГОЛ УЛС, ЕВРОПЫН СЭРГЭЭН БОСГОЛТ, ХӨГЖЛИЙН БАНК
ХООРОНДЫН САНХҮҮЖИЛТИЙН ЕРӨНХИЙ ХЭЛЭЛЦЭЭРИЙН
ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨСЛИЙН ЖАГСААЛТ**

(сая ам. доллар)

№	Төслийн нэр	Зээл	Буцалтгүй тусламж	Техник туслалцаа (сая евро)
1.	“Улаанбаатар-Дарханы замд нэмэлт эгнээ барих” төсөл	2	137.0	1.03
2.	“Улаанбаатар-Дарханы замд нэмэлт эгнээ барих” төслийн нэмэлт санхүүжилт	2	20.0	
3.	“Чойр-Сайншандын 220 кВ-ын 2 хэлхээт 220.4 км урт цахилгаан дамжуулах агаарын шугам, 220/110/35 кВ-ын дэд станц барих” төсөл	2	62.8	12.7
4.	“Дархан-Уул аймгийн нэгдсэн эмнэлэг барих” төсөл	2	43.2	8.0
5.	“Улаанбаатар хотын дулааны сүлжээ” төсөл	2	10.0	4.88 ¹
6.	“Эрдэнэт хотын гамшигт тэсвэртэй байдал” төсөл	2	7.0	6.1 ²
7.	“Улаанбаатар хотын ногоон орон сууц барих” төсөл	2	17.0	8.0
	Нийт		297.0	39.68

---000---

¹ Монголбанкны 2022 оны 11 дүгээр сарын 14-ний ханш 5.0 сая еврог ам. долларт шилжүүлсэн дүн.
² Монголбанкны 2022 оны 11 дүгээр сарын 14-ний ханш 6.25 сая еврог ам. долларт шилжүүлсэн дүн.

Хаяг:

“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакц.
Улаанбаатар-14201, Төрийн ордон 124 тоот
И-мэйл: turiin_medeel@parliament.mn

Утас: 262420

Хэвлэлийн хуудас: 1

Индекс: 200003